

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай жуулийн дараах жэсээфт хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.22 дахь заалт:**

"7.1.22. алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 5 таван жил тутамд тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулалт олгох журмыг Засгийн газар батална;"

**2/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 8.1.11 дахь дэх заалт:**

"8.1.11. хууль тогтоомжид заасан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд аливаа дарамт шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхалтаас-ангид байх гадуурхах;"

**2 дугаар зүйл.** Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын "нисэх бүрэлдэхүүн," гэсний дараа "алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл 3 дугаар зүйл.** Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дараа 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг:**

"9.5. Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчид цалин хөлс олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална."

**3 дугаар зүйл.** Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.3 дахь заалтын "...хилийн отряд, застав болон..." гэснийг "алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги," гэж, 7.1.10 дахь заалтын "сургалтын тэтгэлэг" гэснийг "цалин хөлс" гэж, 7.4 дэх хэсгийн "тусламжид" гэснийг "мөнгөн тусламж, урамшуулалт" гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн 9.2.2 дахь заалтын "удаан жил ажилласны" гэснийг "төрийн тусгай алба хаасан хугацааны" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дугаар эуйл. Энэ хуулийг 2024 оны 01 дугаар сарын 01-ний одрөссөх хүчинд дагаж мөрдөнө.**

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсгийн “анги, агаарын цэргийн салбарт” гэснийг “ангид” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
 хот

### ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд дөрөв доор дурдсан агуулгатай 87.11 дэх хэсэг нэмсүгэй:

“87.11. Дотоод, гадаадын цагдаагийн их, дээд сургуульд суралцаж байгаа цагдаагийн алба хаагчид цалин хөлс олгох журмыг Хууль эүйн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахаас өмнө Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр мөнгөн урамшуулал авсан цэргийн алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.22 дахь заалтад заасны дагуу мөнгөн урамшууллыг үргэлжлүүлэн олгоходоо тухайн алба хаагчийн хамгийн сүүлд мөнгөн урамшуулал авсан хугацааг харгалзан тооцож олгоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг